



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/182

Улаанбаатар хот

Мал эмнэлгийн үйлчилгээний  
зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 13 дугаар зүйлийн 4 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.2.2.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/68 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/410 дугаар захирамж, нийслэлийн Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны А/36 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны төлөвлөгөөт арга хэмжээний хүрээнд хийгдэх гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх, малд эрүүл мэндийн үзлэг хийх, лабораторийн шинжилгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг 2024 оны 3 дугаар сарын 14-ний өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдрийн хугацаанд дүүргийн малчин, мал бүхий айл өрхийн 14586 толгой мал, амьтныг хамруулан хийсэн эмчилгээ үйлчилгээ вакцинжуулалтын ажлын гүйцэтгэлийг үндэслэн үлдэгдэл санхүүжилтийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "ЦЭФ" трейд ХХК-д олгосугай.

2. Мал эмнэлгийн эмчилгээ үйлчилгээ, төлөвлөгөөт вакцинжуулалтын ажлын гүйцэтгэл болон зардлыг хавсралтаар баталсугай.

3. Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээний зардлын үлдэгдэл 4,959,700 (Дөрвөн сая есөн зуун тавин есөн мянга долоон зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Тохижилт, худалдаа, үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т, Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т, санхүүгийн тайлан мэдээг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "ЦЭФ" трейд ХХК (А.Цэрэндагва)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ/2024 он ажил/захирамж

1123200434

Төслийн Багахангай дүүргийн  
... сарын ... ны өдөр  
... захирагч

2024 ОНД МАЛ АМЬТАНД ЭМЧИЛГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭ  
ВАКЦИНЖУУЛАЛТ ХИЙСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН

| № | Нэр төрөл                               | Малын төрөл | Хэмжих нэгж | Малын тоо |
|---|-----------------------------------------|-------------|-------------|-----------|
| 1 | Боом                                    | Бод         | Толгой      | 1500      |
|   |                                         | Бог         | Толгой      | 2998      |
| 2 | Галзуу                                  | Бод         | Толгой      | 1000      |
|   |                                         | Бог         | Толгой      | 197       |
|   |                                         | Нохой       | Толгой      | 100       |
| 3 | Гахайн мялзан                           | Гахай       | Толгой      | 198       |
| 4 | Цусан халдвар (2 удаа)                  | Бод         | Толгой      | 600       |
|   |                                         | Бог         | Толгой      | 1998      |
| 5 | ДХХ Энтеробактери (2 удаа)              | Бог         | Толгой      | 3998      |
| 6 | Дуут                                    | Бод         | Толгой      | 1599      |
| 7 | Гахайн ёлом                             | Гахай       | Толгой      | 199       |
| 8 | Гахайн цусан халдвар, иж балнад (2удаа) | Гахай       | Толгой      | 199       |
|   | ДҮН                                     |             |             | 14586     |

## ОЛГОХ ЗАРДАЛЫН ХУВААРЬ

| №        | Нэгжүүдийн нэр      | 10-р сар  | Нийт дүн  |
|----------|---------------------|-----------|-----------|
| 1        | ЦЭФ трейд ХХК       | 4,659,700 | 4,659,700 |
| 2        | Мал эмнэлгийн тасаг | 300,000   | 300,000   |
| Нийт дүн |                     |           | 4,959,700 |